A person in a light-colored shirt and dark trousers is walking away from the camera down a hallway. The wall is made of large, light-colored rectangular tiles. The floor has a striped pattern. The lighting is dramatic, with strong shadows and highlights.

ХАРИУЦЛАГА  
ХҮЛЭЭХИЙН  
ИД ШИД

МОНГОЛ  
АМЬДРАЛЫН  
ДАСГАЛЖУУЛАГЧ

*ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХИЙН ИД ШИД хэмээх энэхүү цахим ном нь Монгол Амьдралын Дасгалжуулагчийн ажил уран бүтээлийн нэг хэсэг бөгөөд оюуны өмчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан болно.*

*Зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон дахин хэвлэх, хайлтын системд байршуулах, цахим, механик, фото зэрэг ямар ч хэлбэрээр хувилж олшруулах, тараан түгээхийг хатуу хориглоно.*

Copyright © 2012 Monica Batsukh



Амьдралдаа 100% хариуцлага хүлээ.....	4
Бүх юмандаа 100% хариуцлага хүлээ.....	6
Шалтаг тоочихоосоо татгалз.....	8
1. Та болсон үйл явдалыг буруутгаж болно. (Е буюу Болсон Үйлдэл) таны гаргасан Үр Дүн буюу (О)-г бий болгосон. ....	10
2. Үүний оронд та Болсон явдал (БЯ) буюу (Е) тохиолдоход хүссэн Үр Дүн (ҮД) буюу (О) гаран гартал нь Хариу Үйлдэл (ХҮ) буюу (R) -ээ бодолтойгоор өөрчлөх сонголт хийж болно. ....	12
Хэрэв танд гарч буй үр дүн таалагдахгүй бол, хариу үйлдэлээ өөрчил. ....	13
Санхүүгийн хямрал болохыг мэдэж байсан учраас би эртнээс бэлтгэл хийсэн. ....	14
Өнөөдөрийн таны туршлага бол өнгөрсөн хийж байсан сонголтуудын үр дүн ....	15
Хэрэв та хийдгээ хийгээд л байвал урьд олж авдаг байснаа л олж авна. ....	16
Та буруутгаахаа зогс. ....	17
Та гомдоллохоо боль. ....	19
Та буруу хүнд гомдоллоод байна. ....	23
Та өөрөө бүтээнэ гэвэл тохиолдож буй бүх юмыг хүлээн зөвшөөр. ....	24
Санамж дохио ....	26
Амьдрал улам л амархан болдог ....	28
Энэ бол хялбархан ....	29
Энгийн боловч хүмүүс хэрэгжүүлж чаддаггүй. ....	30
Анхаарлаа төвлөрүүл... Таны үр дүн худлаа байдаггүй. ....	32
Яагаад энд байгаагаа тодруул ....	33
Та энэ дэлхий дээр юу хийх гэж ирсэн юм бол? ....	34
Хувийн амьдралын зорилго ....	35
Таны хийдэг ажлуудын ард “Яагаад” гэдэг асуултын хариу юундаа байна? ....	37
Таны дотоод ертөнцийн хүсэл бол аз жаргал ....	39
Амьдралын зорилго дасгал ....	41
Зорилгынхоо төлөө тууштай зогсох ....	43

## АМЬДРАЛДАА 100% ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭ

Та амьдралдаа хувийн хариуцлага хүлээх нь маш чухал. Хэрэв та хариуцлага хүлээж чадахгүй бол таны хүсээд байгаа амьдралын нөхцөл байдал, хэзээ ч өөрчлөгдөхгүй. Өөрчлөлт өөрөөс эхэлнэ.

Монголын өнөөгийн амьдралын хамгийн гашуун бөгөөд харамсалтай зүйлийн нэг нь бид амьдралынхаа өдөр тутмын асуудалд хэн нэгэн хүн эсвэл нийгэм улс төр буруутай гэж үзэх үзэл юм. Гэр бүлийн хүндээ “Чамаас болж миний амьдрал бүтэлгүйтлээ. Чамтай суух ёсгүй байсан юм” гэх мэтээр буруутгадаг. Тэд хэн нэгнийг буруутгаж муулах атлаа өөрийнхөө ажил мэргэжил, гэр бүл, хувийн амьдралынхаа аз жаргалын төлөө юу ч хийдэггүй, ямар ч хариуцлага хүлээхийг хүсдэггүй. Хийж буй ажилдаа бусдад буруугаа тохсон, хариуцлагаас зайлсхийсэн хандлагаар ханддаг нь харамсалтай.

Яг үнэндээ, амьдралын дасгалжуулагчтай хувьчлан ажиллаж, эсвэл дасгалжуулагчийн бүх ажил мэргэжил бүтээлд ганцхан чухал юмыг л заадаг. Энэ нь юу вэ гэвэл, таны өнөөдөр амьдарч байгаа нөхцөл байдал чанар чансаанд цорын ганцхан хүн л хариуцлагатай. Тэр хүн бол та өөрөө.

Та үнэхээр амжилтанд хүрье гэвэл өөрийн амьдралдаа 100% хариуцлага хүлээхээс өөр арга зам байхгүй. Үүнд таны амжилтын түвшин, гаргаж буй үр дүн, таны орлогын хэмжээ, таны өр шир, таны юу бодож мэдэрч буй бүхэн орно гэсэн үг. Энэ бол тийм ч амар юм биш.

Шударгаар хэлэхэд, бидний амьдралд тохиолдож буй бидэнд таалагддаггүй бүх юмандаа бусад ямар нэгэн юмыг оруулж ирж буруутгадаг. Бид өөрсдийн эцэг эхийг буруутгадаг, дарга захиралаа муулдаг, найз нөхдөө буруутгадаг, мэдээлэлийг буруутгадаг, хамтран ажиллагсадаа буруутгадаг, үйлчлүүлэгчээ муулдаг, ханилсан хань ижлээ буруутгадаг, эдийн засгийн байдлыг

буруутгадаг, хороскоп дээр юу хэлсэн байгаагаар нь тайлбарладаг, мөнгөгүй байгаадаа бурууг тохдог, хэн ч бай, юу ч бай хамаагүй тухайн үед санаанд орсон, нүдэнд туссан зүйлээ нэрлээд бид буруугаа тохдог. Гэтэл бид хэзээ ч бидний жинхэнэ асуудал хаана нуугдаад байгаад харахыг хүсдэггүй. Энэ асуудал бол бид өөрсдөө, би өөрөө, чи ч бас өөрөө.

Нэгэн гайхалтай түүх байдгийг хуваалцая л даа... Нэг хүн харанхуйд явж байгаад гудамжны гэрлийн дор өвдөг сөгдөн мөлхөөд юм хайж байгааг олж харжээ. Зөрж өнгөрч байсан мань хүн ихэд гайхаж, туслахаар шийдээд юу хайгаад байгааг нь лавлаж асуужээ. Нөгөө хүн хариулахдаа гэрийнхээ түлхүүрийг гээчихсэн гэж. Тэгэхээр туслахаар шийдээд зэрэгцэж мөлхөж эхэлжээ. Цаг гаруй хайгаад олохгүй цөхрөхдөө манай хүн “Бид энүүгээр хаа сайгүй л үзлээ, олсонгүй. Чи энд хаясан нь яг үнэн юм уу?” гэж асуув. Гэтэл нөгөө хүн, “Үгүй, би түлхүүрээ гэртээ гээчихсэн юм. Гэхдээ энд гудамжны гэрэл асаалттай болохоор нь л...” гэж тайлбарлажээ.

Бид яг үүнтэй адилхан зүйлийг хийдэг, бидний гадна талд байгаа зүйлээс асуултынхаа хариултыг олохыг хүсдэг. Одоо би яагаад өөрийнхөө хүссэн чанартай сайхан амьдралаа өдий хүртэл бүтээж чадаагүй вэ гэдэг асуултандаа хариултыг гаднаас хайхаа зогсооё!

Хариулт нь Танд бий! Өөр хэнд ч биш. Амьдралдаа амжилт гаргахад та өөрөө 100% хариуцлагыг үүрэх зайлшгүй шаардлагатай. Үүнээс бага хариуцлага хүлээх гэж хөөцөлдөх шаардлага байхгүй.

## БҮХ ЮМАНДАА 100% ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭ

АНУ-ын тэрбумтан У. Клемент Стоне (W. Clement Stone) 1969 онд нэгэн залуугаас

“Чи 100% хариуцлага хүлээж чаддаг уу?” гэж асуухад залуу бодолхийлж байснаа, “Би тэгж л боддог шүү дээ” гэж хариулжээ.

Тэгэхэд тэрээр, “Чи тэгээд хариуцлага хүлээдэг юм уу эсвэл үгүй юм уу?” лавлахад, залуу “Би сайн мэдэхгүй байна л даа.” гэж ая засчээ.

“Чи урьд нь өөрийнхөө золгүй явдалд хэн нэгэн хүнийг буруутгаж байсан уу? Тэр тухайгаа бусдад гомдоллож байсан уу?” гэхэд

“Хммм, Би тийм байх л гэж таамаглаж байна” гэж залууг хэлэхэд

“Битгий таамагла, бод”

“Тийм юм байна”

“Тэгвэл чи өөртөө 100% хариуцлага хүлээдэггүй гэсэн үг юм байна. 100% хариуцлага хүлээнэ гэдэг нь өөртөө тохиолдох бүх юмыг өөрийнхөө гараар бүтээхийг хүлээн зөвшөөрч байна гэсэн үг. Энэ нь чиний амьдралд туулсан туршлагын бүх учир шалтгааныг ойлгож ухамсарлаж байгаагийн шинж. Хэрэв чи үнэхээр амжилтанд хүрэхийг хүсч байгаа л бол?! Би чамайг хүсч байгааг мэдэрч л байна. Тэгвэл чи яг одооноос эхлээд биеэ буруутгаж, гомдоллохоо болиод амьдралынхаа төлөө 100% хариуцлагыг хүлээ, үүн дотор чиний гаргасан амжилт ч, алдаа ч аль аль нь багтана. Энэ бол амжилт уналт 2ын алийг сонгох сонголтын гарааны чинь эхлэл. Энэ бол өнөөдрийг хүртэл чиний хийсэн бүх юмсийг чи өөрөө бий болгосон гэдгээ хүлээн зөвшөөрсөн ухамсар, өнөөдрөөс хойш ирээдүйд бүтээх хүссэн бүх юмаа чи өөрийнхөө гараар

бүтээнэ гэсэн хариуцлага. Чи ойлгож байна уу? Чи өнөөдрийг хүртэл бүх юмаа бүтээсэн гэдгээ бүрэн ухамсарлаж хүлээн зөвшөөрвөл ирээдүйд дахин үүнийгээ бүтээх эсвэл нураах бүрэн боломжийг гартаа төвлөрүүлж чадах чадвар чинь чамд орж ирнэ гэсэн үг. Хүсвэл чи бүтээж чадна гэсэн үг. Чи ойлгов уу?”

“Тийм ээ, Ноёнтон. Би ойлголоо”

“Чи өөрийнхөө амьдралд 100% хариуцлага хүлээхэд бэлэн байна уу?”

“Тийм ээ, Ноёнтон. Би бэлэн байна!” хэмээн залуу нэг дуугаар хашгирчээ. Энэ цагаас хойш энэ залуу 100% хариуцлага хүлээж эхэлсэн, түүгээрээ ч тэрээр амжилтанд хүрсэн гэдэг. Энэ залуу хүний нэрийг Жэйк Канфиэлд гэдэг. Магадгүй НУУЦ номын хамтран бүтээгсэдийн нэг гэдгээр нь та таних байх.

## ШАЛТАГ ТООЧИХООСОО ТАТГАЛЗ

Уналтын 99% нь шалтаг тоочдог зуршилтай хүнээс болж үүсдэг.

Хэрэв та амьдралдаа хүссэн мөрөөдөлдөө хүрье гэвэл, та өөртөө 100% хариуцлага хүлээх зайлшгүй шаардлагатай. Энэ нь бүх хэлдэг шалтагуудаа зогсоож, хохирогчийн үлгэр ярьдагаа больж, яагаад хийж чадахгүй байгаагаа дурьдахаас татгалзаж, өнөөдрийг хүртэл яагаад амжилтанд хүрээгүйгээ хэлэхээ харзнаж, гаднах нөхцөл байдлыг буруутгааа зогсооно л гэсэн үг. Та энэ бүхнийг насан туршдаа дахин хэзээ ч хэрэглэхгүйгээр таягдан хаях шаардлагатай.

Оронд нь та өөрийгөө урьд байнга хүч чадал нь байсан, сонголт нь байсан гэдгийн ялгааг олж таних хэрэгтэй байгаа юм. Та өөртөө өөрчлөлт хийх боломжийг олгох, хүссэн үр дүнгээ гаргахын тулд бүхнийг зөв болгоход туслах хариуцлагыг гартаа оруулж авах нь чухал. Ямар нэгэн байдлаар аливааг үгүйсгэх, анхаарал болгоомжгүй хандлага, буруу зөв байх вий гэсэн сэтгэлийн зовнил, аюулгүй байхын тулд та тухайн үед тулгараад байсан хариуцлагыг анзаараагүй, тэр хүч чадал, эрх мэдлийг мэдрээгүй өнгөрсөн байж болно. Гэхдээ одоо энэ чухал биш. Өнгөрсөн асуудал. Юу чухал вэ гэвэл, одоо энэ мөчөөс эхлээд та өөрөө сонгоно. Юу нь зөв бэ гэж бодсоноо хариуцлагатайгаар сонгоно. 100% хариуцлага, унасан ч боссон ч таны бүрэн хариуцлага өөр хэний ч буруу биш, зөвхөн таны хариуцлага гэдгийг мэдэрч хийсэн шийдэлүүд. Энэ мөчөөс хойш юу ч болсон ч, болоогүй ч 100% хариуцлага хүлээн шийдвэр гаргах тэр их хүч чадал танд энэ мөчөөс орж ирж байна.

Хэрэв энэ бүхэн таны хүссэнээр болоогүй бол, гээд та өөрөөсөө ингээд асуугаад үз, “Би яаж явж байгаад үүнийг хийчихэв?! Би юу бодоод явсан юм бол? Би юунд итгэж байсан юм бол? Би юу гэж хэлээд эсвэл юу гэж хэлээгүй



юм бол? Би юугий нь хийгээд, юугий нь хийгээгүй юм бол? Би юу бүтээгээд байсан мөртлөө, юуг бүтээхээс зайлсхийгээд байсан юм бол? Би юу хийгээд тэр хүнийг надтай ингэж харилцах нөхцөлийг бүтээчихсэн юм бол? Дараагийн удаад би яаж өөрчлөлт хийж байж хүссэн үр дүнгээ бий болгох хэрэгтэй вэ?”

Ноён Стоне, Лос Анжелосийн сэтгэл зүйч Доктор Робэрт Ресник нарын гаргасан нэгэн томъёоллыг өнөөдөр танд хүргэе. Энэ томъёо 100% хариуцлага гэж яг юуг хэлдэг вэ гэдгийг улам тодорхой болгож өгсөн юм.

Томъёо нь,

Англи хэл дээр

***E + R = O (Event + Response = Outcome)***

Монгол хэл рүү хөрвүүлвэл,

***БЯ + ХҮ = ҮД (Болсон Явдал + Хариу Үйлдэл = Үр Дүн)***

Үүний суурь ухагдахуун нь таны амьдралдаа туулж буй бүх үр дүн (амжилт байна уу, эсвэл уналт байна уу хамаагүй, баян байна уу эсвэл ядуу байна уу хамаагүй, эрүүл байна уу эсвэл өвчтэй байна уу хамаагүй, янагийн дотно холбоотой байна уу эсвэл танихгүй хүйтэн харилцаатай байна уу ялгаагүй, аз жаргалтай байна уу эсвэл зовж зүдэрч байна уу хамаагүй) гарч ирж байгаа үр дүн нь урьд нь тохиолдсон болсон явдал дээр та ямар хариу үйлдэл хийж байснаас шалтгаалж байгаа юм.

Хэрэв танд одоогийн болж байгаа үр дүн таалагдахгүй бол ерөнхийдөө маш энгийн 2 янзын аргаар сонголт хийж болох юм.

*1. Та болсон үйл явдалыг буруутгаж болно. (Е буюу Болсон Үйлдэл) таны гаргасан Үр Дүн буюу (О)-г бий болгосон.*

Нөгөө утгаар нь хэлбэл, та эдийн засгийн хямралыг буруутгаж болно, цаг агаарын байдлыг буруутгаж болно, мөнгөгүй байгаагаа буруутгаж болно, боловсролгүйгээ хэлээд байж болно, арьс өнгөний үзэл, хүйсний ялгаа, төрийн бодлогын бурууг дурьдаж болно, таны дарга захиралын бурууг харж болно, нөхрөө эсвэл эхнэрээ ч үүнд тохоож буруутгаж болно, хамтран зүтгэгчдийнхээ бүтэлгүйг гайхаж болно, улс төрийн таагүй уур амьсгалыг хэлээд байж болно, системийн бүтэлгүйг эсвэл гээд л юу л бол юу, нүдэнд харагдсан, санаанд буусан юм болгоныг дурьдаад байж болно. Эдгээр шалтагууд байдаг гэдгийг огтхон ч үгүйсгэхгүй. Гэхдээ эдгээр нөхцөлүүд л зайлшгүй бидний амьдралыг шийдэж байгаа юм бол өнөөдрийг хүртэл хэн ч амжилтанд хүрч чадахгүй.

Жэйкие Робинсон хэзээ ч сагсан бөмбөг тоглохгүй байсан

Сиднэй Пойтиэр, Дензел Вашингтон нар хэзээ ч кино од болохгүй.

Дианнэ Фэйнштэйн, Барбара Боксэр нар хэзээ ч АНУ-ын сенаторууд болохгүй.

Эрин Брокович хэзээ ч хортой усны бохирдлыг олж илрүүлэхгүй байх байсан.

Билл Гэйтс хэзээ ч Микрософтийг үүсгэн байгуулахгүй.

Стиев Жобс хэзээ ч Аппле Компютерийг эхлэхгүй байх байсан.

Яагаад энэ бүхэн боломжгүй гэж? гээд бүх л талаас нь бодоод үзэхээр, хичнээн зуун мянган хүмүүс яг адилхан нөхцөлд байж байгаад амжилтанд хүрсэн. Хичнээн зуун хүмүүс өнөөдөр тэднийг хязгаарлаж зааглаад байдаг хүчин зүйлсийг давж гарсан. Бидний гадна талд байгаа нөхцөл байдал

биднийг зогсоодог юм биш, энэ бол зөвхөн Чи өөрийгөө зогсоодог! Бид өөрсдийгөө л зогсоодог! Бид ямар нэгэн хязгаар, үл итгэсэн бодолдоо хөтлөгдөж, бууж өгсөн хүний зан чанар руу хөтлөгддөг. Бид өөрсдийнхөө энэ бууж өгсөн энэ ялагдагчийн байр сууринд байгаагаа үгүйсгэж дарахын тулд өөрийгөө хамгаалсан өөр нэгэн төрлийн шалтаг тайлбарлаж, өөрийгөө тайвшруулахын тулд өөр төрлийн хамгаалалтаа алдсан дадал (тамхи татах, архи уух гэх мэт) руу шилждэг. Бид хэрэгцээтэй мэдээлэлийг үгүйсгэж эхэлдэг, өөрсдийгөө дайчлахаас зайлсхийж эхэлдэг, бид шинэ зүйл сурч өөрийгөө хөгжүүлж боловсруулах хүсэлгүй болдог, бид олж байгаа орлогоосоо илүү зарлагадаж эхэлдэг, бид ирээдүйдээ хөрөнгө оруулахаа орхигдуулдаг, бид үнэнгээ хэлэхээс зугтдаг, бид маргаан зөрчилдөөнөөс зайлсхийж асуудлаа шийдэлгүй өнгөрүүлдэг, бид өөрсдөө юу хүсэж байгаагаа асуулгүйгээр яагаад энэ бүхэн бүтэлгүйтдэг вэ гэдэгт л гайхшралаа төвлөрүүлдэг.

Гашуун боловч үнэн, энэ бол дийлэнх хүмүүсийн хийдэг зүйлс. Тэд асуудал байгаа жинхэнэ газраа ухаж үздэггүй, өөрөөсөө гаднах өөр газар руу чиглүүлж түр зуурын тайтгарал авдаг. Тэдний хийх бүх юманд шалтаг л мундахгүй их гарч ирдэг.

*2. Үүний оронд та Болсон явдал (БЯ) буюу (Е) тохиолдоход хүссэн Үр Дүн (ҮД) буюу (О) гаран гартал нь Хариу Үйлдэл (ХҮ) буюу (R) - ээ бодолтойгоор өөрчлөх сонголт хийж болно.*

Та боддог бодлоо өөрчилж болно, харилцдаг харилцааныхаа аргыг өөрчилж болно, өөрийнхөө болон хорвоо дэлхийн тухай толгойдоо эргэлдүүлдэг үзэл бодлоо өөрчилж болно, та өөрийнхөө гаргадаг зан авираа өөрчилж болно. Яг үнэндээ та ийм юмнуудыг л хянаж чадна. Харамсалтай нь бидний ихэнх нь өдөр тутмын дадал зуршилдаа автагдаад зан авираа өөрчилж чаддаггүй. Бид хуучин нөхцөл байдалдаа ханддаг хариу үйлдэл зуршилдаа барьцалдаад өөрчлөлт хийж чаддаггүй. Хүүхдүүддээ ханддаг эцэг эхийн харилцаа, ажил сургууль дээрээ харилцдаг хамт олон гээд л бүх харилцаа холбооны орчин нөхцөлдөө барьцалддаг. Бидний гаднах орчинд нөлөөлж байгаа зүйлстэй холбогддог рефлексээрээ бид холбогддог. Та өөрийн чухалчилж үздэг юмс, зорилгодоо тохируулж юу хэлэх, юу хийх бүх юмсаа бодолтойгоор хянаж болно.

*ХЭРЭВ ТАНД ГАРЧ БУЙ ҮР ДҮН ТААЛАГДАХГҮЙ БОЛ, ХАРИУ  
ҮЙЛДЛЭЭ ӨӨРЧИЛ.*

Жишээ аваад энэ талаар ярилцая л даа.

Одоогоос хэдэн жилийн өмнө Английн нисэх онгоцны буудал дээр цаг агаарын байдлаас саатсан онгоцны зорчигчдоос хийсэн нэгэн сурвалжлага BBC телевизийн мэдээний сувгаар гарч байсан юм. Саатсан зорчигчдийн нэг нь ихэд л бухимдаж, “British Airway” дандаа л ингэж нислэг хойшлуулдаг, Лондонгийн нисэх онгоцны буудал гэж байнгын асуудалтай, би энд ирэх болгондоо цаг ажил алдаж оройтох юм” гэх мэтчилэн гомдоллож байсан бол. Өөр нэгэн зорчигч “Агаарын байдал сайжраад нислэг сайжрахыг хүлээн зуураа ном л уншиж сууна. Ер нь надад ингэж тайван суух цаг зав олддоггүй юм байна гэдгийг сая л мэдлээ. Би зүгээрээ” хэмээн тухалсан зорчигч тайван хариулж билээ.

Одоо үүнээс харахад нэгэн ижил төрлийн үйл явдал тохиолдоход энэ хоёр хүн хоёулаа ижил нөхцөлд баймаар л юм. Гэтэл энэ 2 хүн шал өөр хандлагатай. Нэг нь уур бухимдалтай, нөгөө нь аз жаргалтай байна. Цаг агаарын байдлыг тэдний аль аль нь хянаж өөрчилж чадахгүй. Онгоцны нислэгийг ч ялгаагүй. Үйл явдал нь яг адилхан тохиолдсон боловч энэ 2 хүн өөр өөр Хариу Үйлдэл үзүүлж, өөр өөр Үр Дүнг бий болгож байна. Нэг нь бухимдан гомдоллож сөрөг хандлага илэрхийлж байхад, нөгөө нь өөдрөг сэтгэл хангалуун хандлага гаргаж байна. Эдгээр 2 хүний тухайн цаг мөчид бий болгож байгаа Үр Дүн ч бас харьцангуй ялгаатай.

## *САНХҮҮГИЙН ХЯМРАЛ БОЛОХЫГ МЭДЭЖ БАЙСАН УЧРААС БИ ЭРТНЭЭС БЭЛТГЭЛ ХИЙСЭН.*

Нэгэн брэндийн машины худалдах цэгийн борлуулалтын хэмжээ санхүүгийн хямралаас шалтгаалж эрс буурчээ. Хүмүүс тэр машиныг худалдан авах нь багасан багассаар санхүүгийн хямралд өртөх магадлал өндөр (Үр Дүн) гарч байгаа нь тодорхой болж эхлэв. Ийм гарах нь тодорхой болж буй тул хэрэв тэд Хариу Үйлдэлээ өөрчлөхгүй л бол удахгүй тэд бизнесээ алдах аюултай. Тэдний ердийн Хариу Үйлдэл дотор урьдынхаа адил сонин, радиогоор реклам сурталчилгаагаа хийгээд л хүмүүс ирэхийг хүлээдэг байлаа. Энэ арга хүссэн Үр Дүнг авчрахгүй байгаа нь ойлгомжтой. Ийм Хариу Үйлдэл хийсний Үр Дүнд борлуулалт буурч байна. Тиймээс тэд хэд хэдэн шинэ зүйлсийг туршиж үзжээ. Тэдгээр аргуудын хамгийн амжилттай байсаны нэг нь гэвэл, тэр шинэ машинуудыг баян хүмүүс амьдардаг, очдог, зугаалдаг үнэтэй тансаг газруудад аваачиж үнэгүй бага зэрэг аялал хийхийг урьжээ. Бодоод үз дээ, хэрэв Та цоо шинэ үнэтэй гоё машин унаад хэдэн цаг зугаалж байгаад буугаад өөрийнхөө хуучин машин руугаа ороод суухаар ямар санагдах вэ? Мэдээж хуучин машиндаа суугаад л сэтгэл ханамж авдаг байсан тааламжтай байдал нь өөрчлөгдөөд ирнэ. Өнөөдрийг хүртэл хуучин машин боломжийн давгүй байсан боловч, шинэ машин унаад туршаад үзсэний дараа хуучнаа голж эхэлнэ. Энэ хүмүүст яг л ийм юм тохиолджээ. Туршиж унаж үзсэнийхээ дараа л тэр хүмүүсийн нилээн өндөр хувь нь машиныг худалдаж авахаар болж, зарим бүр лийзинг үүсгэж өөрийн болгон авчээ.

Машин борлуулагчид энэ тохиолдолд санхүүгийн хямрал (Болсон Явдал) болсон ч, борлуулалт муудаж, дэлгүүрээ хаах (Үр Дүн)-г хүсээгүй, иймээс машины борлуулалтаа сайжруулах (Үр Дүн) -ын тулд олон янзын шаардлагатай (Хариу Үйлдэл)-г хийж эхэлсэн. Өнгөрсөн жилүүдийнхээ тооцоотой харьцуулахад энэ Үр Дүн нь санхүүгийн хямрал ирэхээс ч өмнө байсан Үр Дүнгүүдээс харьцангуй өндөр гарчээ.

*ӨНӨӨДРИЙН ТАНЫ ТУРШЛАГА БОЛ ӨНГӨРСӨНД ХИЙЖ  
БАЙСАН СОНГОЛТУУДЫН ҮР ДҮН*

Өнөөдөр таны мэдэрч буй бүх туршлага, дотоод ертөнцдөө ч тэр, гадаад ертөнцдөө ч тэр, өнгөрсөн хугацаанд болсон Үйл Явдалуудад хэрхэн Хариу Үйлдэлүүд хийсний үр дүн. Жишээлбэл

Үйл Явдал, Танд 400 долларын шагнал өгч гэж бодъё

Хариу Үйлдэл, Та түүнийг оройд нь зугаалаад л үрэн таран хийчихэж

Үр Дүн, *Та одоо ядуу*

Үйл Явдал, Танд 400 долларын шагнал өгч гэж бодъё

Хариу Үйлдэл, Та хувьцаанд хөрөнгө оруулсан

Үр Дүн, *Та үр ашгийг нь өсгөсөн.*

Та энэ яваа насандаа гуравхан зүйл дээр л хяналт тавьж чадна, энэ нь, таны бодол оюун санаа, таны төсөөлөл, таны хийх үйлдэл (таны зан авир). Одоо та эдгээр гурван зүйлсийг хэрхэн ашиглаж туршлагаа өөрчлөх эсэх нь таны гарт. Хэрэв та одоогоор туулж өнгөрүүлж буй туршлагаа өөрчлөө гэвэл эдгээр аргуудаар Хариу Үйлдэлүүдээ өөрчилж болно. Гутранги сөрөг үзлээ өөдрөг эерэг үзэл болгон өөрлөх. Мөрөөддөг мөрөөдлөө өөрчлөх. Дадал зуршилаа өөрчлөх. Юу уншихаа өөрчил. Ямар хүнтэй найзалж явахаа өөрчил. Ярьдаг хэлбэр загвараа өөрчил.

*ХЭРЭВ ТА ХИЙДГЭЭ ХИЙГЭЭД Л БАЙВАЛ УРЬД ОЛЖ АВДАГ  
БАЙСНАА Л ОЛЖ АВНА.*

Ийм нэгэн мэргэн үг байдаг юм, “Хийдэг зүйлээ давтан хийсэн атлаа өөр үр дүн хүснэ гэдэг бол тэнэг хүний шинж”. Архичин хүн архиа уугаад амьдралаа сайжирна гэж найдвал тэнэгийн шинж. Үүнтэй яг адилхан та урьдын хийдэг байсан зан авираа гаргасан атлаа амьдралаа өөрчлөгдөнө гэдэгт найдна гэдэг бол яг л галзуу хүнээс ялгаагүй.

Хийдэг юмаа өөрчилж эхэлсэн л мөчөөс таны амьдралд өөрчлөлт орно! Хэрэв таны өнөөдрийг хүртэл хийсэн эсвэл одоо ч үргэлжлүүлэн хийж байгаа бол үйлдлүүд таны хүссэн “үр дүн”-г ямар нэгэн талаараа бүтээсэн л байгаа. Хэрэв таны амьдралд өнөөг хүртэл гарч байгаа үр дүн нь танд таалагдахгүй байгаа л бол, та ямар нэгэн байдлаар өөр үйлдэл хийх хэрэгтэй болох нь! Мэдээж өнөөдрийг хүртэл хийж байгаагүй шинэ зүйлийг туршиж үзнэ гэсэн үг.



## ТА БУРУУТГАХАА БОЛЬ

“Бусдыг буруутгана гэдэг тэр чигээрээ цагийн гарз! Бусдын гаргаж буй алдааг харлаа гээд таны амьдрал сайжирч өөрчлөхгүй.” - Уайне Дайэр

(“Үнэхээр үнэхээр үнэхээр их хүссэн юмаа Хэрхэн олж авах вэ?” номын зохиолч)

Та хэн нэгнийг буруутгаад, эсвэл танд ямар нэгэн юм нь дутагдаад, эсвэл өөр бусад зүйл таныг хянаад байгаа мэт бол та эрх дураараа чөлөөтэй амжилтанд хүрэхгүй. Хэрэв та ялагч болохыг хүсвэл, үнэн бодит байдлаа хүлээн зөвшөөр, та өөрөө эдгээр сонголтуудыг хийсэн, бодлуудыг бодсон, одоо байгаа нөхцөл байдлыг бий болгосон гэдгээ хүлээн зөвшөөр! Энэ бол зөвхөн таны өөрийн сонголтууд!

1. Та өөрөө буруу хоол хүнс хэрэглэсэн.
2. Та өөрөө Үгүй гэж хэлж чадаагүй.
3. Та өөрөө дургүй ажлаа хийнэ гэж амалсан.
4. Та өөрөө л дургүй ажилдаа үлдсэн.
5. Та өөрөө хэрэггүй зүйлд орооцолдсон.
6. Та өөрөө л гэнэдэж итгэсэн.
7. Та өөрөө дотоод сэтгэлээ сонсолгүй үгүйсгэсэн.
8. Та өөрөө мөрөөдлөө хаясан.
9. Та өөрөө тэр бүхэнд мөнгөө зарцуулсан.



10. Та өөрөө анхаарлаа хандуулаагүй.

11. Та өөрөө ганцаараа хийх гэж зүтгэсэн.

12. Та өөрөө л хүмүүс тийм хандах боломж олгосон.

13. Та өөрөө эрхээ хамгаалаагүй.

14. Та өөрөө урсгалаараа явсан.

15. Та өөрөө сул дорой зан гаргасан.

## ТА ГОМДОЛЛОХОО БОЛЬ

“Бөмбөг унасанд гомдоллож буй хүн өөрөө л бөмбөгөө унагасан хүн нь байж таардаг.” - Луи Холтз (6 удаагийн коллежуудын сагсан бөмбөгийн аварга багуудыг бүрдүүлсэн дасгалжуулагч)

Одоо бүгдээрээ гомдоллоно гэж яг юу байдаг талаар илүү тодорхой үзье. Ямар нэгэн юманд гомдоллоно гэдэг чинь ардаа та ямар нэгэн байдлаар үүнээс дээр юм байгаа гэдэгт итгэсэн байна гэсэн үг. Таны хүсэхгүй байгаа ямар нэгэн юм, орчин нөхцөлийг бүтээсэнд нь та хариуцлага хүлээхийг хүсэхгүй байгаа. Дахиад жоохон тодруулах гээд үзье. Хэрэв та үүнээс дээр юм байдаг гэж итгээгүй бол та ингэж гомдоллохгүй байсан байх. Магадгүй та арай л ахиухан мөнгө, томхон байр, сэтгэл ханамж авчрах ажил, илүү баяр баясгалан, арай дотно хайрын харилцаа гэх мэтийг та хүсээд байсан байж болно.

bitgii med zarim zuiliig ter n deerur dund hurgene

Нөгөө талаар хүмүүс гомдоллохдоо ихэвчлэн үүнийг сайжруулахын тулд ямар нэгэн юм хийхийг хүсэж байгаагаа илэрхийлдэг. Бид ямар нэгэн юманд чадваргүйдээ гомдоллодоггүй, харин үүнийг өөрөөр хийх боломж байгаа гэдгийг мэдрэхдээ гомдоллодог.

Дэлхийн таталцалын хүчний тухай хүмүүс гомдоллож байхыг та сонсоогүй биз дээ? Мэдээж, үгүй. Яагаад иймэрхүү юманд гомдоллоод байдаггүй гэдгийг та мэдэх үү? Газрын таталцалын хүч байгаагүй бол хүмүүс өндрөөс доошоогоо унахгүй, аяга таваг газар унахдаа хагарахгүй гэх мэт. Гэхдээ хэн ч дэлхийн таталцалын хүчийг зогсоож чадахгүй гэдгээ мэддэг. Ийм зүйл оршин тогтнодог гэдгийг хүн бүр хүлээн зөвшөөрсөн. Бид гомдоллоод юу ч өөрчилж чадахгүй гэдгээ мэддэг учраас гомдоллоод байдаггүй. Яг үнэндээ бид таталцалын хүчний давуу талыг ашиглаж сурцгаасан. Бид бохироо хүртэл таталцалын хүчийг ашиглаж муу усны сувгийг бүтээж чадсан. Бүр сонирхолтой нь бид

дэлхийн таталцалын хүчийг ашиглаад тоглож сурсан. Бүх спорт таталцалын хүчийг ашигладаг. Сагсан бөмбөг, гольф, цанаар гулгах, өндөрт харайх, гимнастик гээд бүх л спортод таталцалын хүч хэрэглэгддэг.

Таны гомдоллодог бүх юмсыг та өөрчилж болдог юм байдаг. Байгалаас заяасанаараа, нөхцөл байдлаараа ч та өөрчилж чадах боловч өөрчлөхгүй байх сонголт хийсэн. Та илүү сайн ажил хийж болно, хайрлах хань олж болно, мөнгө хийж болно, сайхан байшинд амьдарч болно, боломжийн хөршүүдтэй тухлаг орчинд очиж болно, эрүүл хүнс идэж болно гэх мэт. Гэхдээ эдгээр бүх юмс таныг өөрчлөлт хийхийг шаарддаг.

Магадгүй таны шаардаад байгаа зүйлсийг бүтээхийн тулд та хариу үйлдэлүүд хийж болно. Дээр дурьдаж байсан бусдыг буруутгадаг шалгаануудад зориулж хийж болох зүйлсийг бичихэд л...

1. Та хэрэглэдэг хоол хүнсээ өөрчилж болно.
2. Та хүсээгүй зүйлдээ Үгүй гэж хэлж болно.
3. Та дургүй ажилд амлалт гаргахгүй байж болно.
4. Та ажлаасаа гараад, дуртай сонирхдог ажлаа олж болно.
5. Та тодорхой зорилготойгоор юу хийхээ шийдэж болно.
6. Та итгэл өгөх эсэхээ нухацтайгаар шийдэж эрсдэлийг тооцож болно.
7. Та дотоод сэтгэлд байгаа үнэн мэдрэмжээ сонсож, шийдэж болно.
8. Та мөрөөдлөө итгэж түүнийг хэрэгжүүлэх гараагаа хийж болно.

9. Та юунд ямар зорилгоор мөнгөө зарцуулахаа хариуцлагатайгаар бодож болно.

10. Та орчин нөхцөлдөө анхаарлаа төвлөрүүлж болно.

11. Танд хүч нэмэх хамт олон баг бүрдүүлж болно.

12. Та өөрийгөө хүндэлж, хайрлаж, харилцан хүндэтгэл бүтээж болно.

13. Та өөрийн байр сууриа хамгаалж болно.

14. Та өөртөө итгэж, тууштай зүтгэж болно.

15. Та өөрийгөө ялан дийлж болно.

Та яагаад эдгээр зүйлсийг хийж болохгүй гэж? Учир нь эдгээр хариу үйлдэлүүд бүгд тодорхой хэмжээний эрсдэлтэй тулгардаг учраас л тэр. Та ажлаасаа гарчихвал, ажилгүй болчихно гэдэг эрсдэлээс айсан, гав ганцаараа үлдэж, бусдын өмнө эвгүй байдалд орохоосоо айсан. Та алдахаасаа айсан, нүүр тулж үзэлцэхээс айсан, буруу болж таарах вий гэдгээс айсан. Та эцэг эх, эргэн тойрны хүмүүсийн хэлэх үгнээс айсан.

Өөрчлөлт хийнэ гэдэг тодорхой хэмжээний оюун ухаан, мөнгө, цаг шаарддаг.

Заримдаа энэ бүхэн эвгүй, хэцүү эсвэл жоохон толгой эргэмээр санагдаж ч болох юм. Тиймээс ийм эвгүй байдлууд эрсдэлээс зайлсхийхийн тулд тухайн нөхцөл орчиндоо үлдэж, гомдоллож эхэлдэг.

Өмнө нь бидний ярьж байсанчлан, гомдоллоно гэдэг бол ямар нэгэн зүйлийг сайжруулахыг хүссэн үүнээс дээр юм байгаа гэдэгт итгэсэн итгэлээс үүдэлтэй

боловч эрсдэлийг давахаас зайлсхийж байгаагаараа ялгардаг. Одоо байгаа байдлаа хүлээн зөвшөөрөөд, хийсэн сонголтондоо хариуцлага хүлээгээд, гомдоллохоо болиод, хүссэн амьдралаа бүтээхийн тулд эрсдэл хүлээхийн алийг нь ч хийж болно.

Хэрэв та өөрийнхөө байгаа газраас хүссэн газар хүртэлээ өөрчлөлт хийнэ л гэвэл, ямар нэгэн байдлаар эрсдэл хийхээс ч өөр аргагүй.

Тиймээс гомдоллохоо болих шийдвэр гаргаад, гомдолоод байдаг хүмүүсээс зай барьж эхлээд, амьдралдаа хүсээд байгаа бүхнээ бүтээх их аяндаа орж болно.

## ТА БУРУУ ХҮНД ГОМДОЛЛООД БАЙНА.

Заримдаа хүмүүс огт асуудлыг нь шийдэж чадахгүй буруу хүмүүс рүү гомдолоо илэрхийлээд байдгийг та анзаарсан уу? Тэд ажил дээрээ очоод эхнэр, нөхрийнхөө тухай гомдоллоцгоодог, тэд гэртээ хариад ажил дээрээ байгаа асуудлуудаа гомдоллоцгоодог. Яагаад? Учир нь ингэхэд их амархан учраас, энийг хийхэд эрсдэл байдаггүй учраас. Гэртээ эхнэр нөхөртэйгөө нүүр тулж таалагдахгүй байгаа асуудлаа ярихад тодорхой хэмжээний зориг шаарддаг учир. Даргаасаа илүү сайн төлөвлөгөө гаргаач гэж шаардахад зориг шаарддагаас гадна, зөвхөн дарга л тэр өөрчлөлтийг хийж чадах учраас. Эхнэр нөхөр чинь ийм өөрчлөлтийг чадахгүй.

Гомдоллох хүнээ олж гомдоллоход хүсэж буй үр дүн гаргахад тодорхой үйлдэл өөрчлөлт өгдөг. Амжилттай яваа хүмүүс үүнийг л хийдэг. Ийм үйлдэл илүү үр дүн өгдөг. Хэрэв та хүсээгүй орчин нөхцөлд байгаа бол үүнийгээ өөрчлөх юм хий, эсвэл тэр ажлаасаа гар. Хэрэв танай гэр бүлийн харилцаа таны дургүй тааламжгүй орчин бүрдүүлдэг бол та үүнийгээ сайжруулах юм хийх эсвэл гэр бүлээсээ салсан нь дээр. Ажлын байр чинь таалагдахгүй бол мөн л адил ажлаа сайжруулах юм хий эсвэл цоо шинээр ажил хай. Аль нь ч бай, та амьдралдаа нөлөөлөхгүйц дорвитой өөрчлөлт хийнэ. Хуучны нэг үг байдаг, “Зүгээр суухаар, зүлгэж суу” гэж. Ямарваа нэгэн асуудал муухан нөхцөл байдалтай эвлэрч сууснаас сайжруулах өөрчлөлт хийж эхэлсэн нь хавьгүй дээр. Дэлхий ертөнц таны өмнө өртэй юм биш. Бүх юм таны хүссэнээр биш байж болно. Харин та өөрөө энэ бүхнийг бүтээх ёстой.

**ТА ӨӨРӨӨ БҮТЭЭНЭ ЭСВЭЛ ТАНД ТОХИОЛДОЖ БУЙ БҮХ ЮМЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХӨӨС ӨӨР АРГАГҮЙ.**

Хүчтэй байхын тулд та өөртөө шаардлагатай байр суурийг бүтээх эсвэл байгаа бүх юмыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Бүтээнэ гэдэг утгыг таны өөрийн хийсэн болоод хийгээгүй ажлын сонголтоор уг зүйлийг танд тохиолдуулахыг хэлж байгаа юм. Хэрэв та бааранд танаас том биетэй согтуу хүн рүү дөхөж очоод доромжилж өдвөл тэр хүн уурандаа таныг барьж аваад зодох нь ойлгомжтой. Зодуулсан та эмнэлэгт хүргэгдэж ч болно. - Энэ бол таны бүтээсэн үр дүн, шууд ойлгомжтой.

Гэтэл зарим нөхцөлийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү ч үе тохиолддог. Та өдөр бүр оройтож ажиллаад, стрестэж ядарсан хүн дуугүйхэн хоолоо идээд, ядарсандаа юу ч хийхийг хүсэхгүй зурагт үзээд, салхинд гарч алхалгүй, хүүхдүүдтэйгээ тоглох ч хүсэлгүй хэдэн жил болж гээд бод. Эхнэр чинь юм асуухад дуртай дургүй “Дараа больё!” гээд хэлчихдэг. 3 жилийн дараа нэг өдөр ажлаа тараад ирэхэд эхнэр чинь ширээн дээрээ салах хүсэлтээ бичээд хүүхдүүдээ аваад ээж аав руугаа явсан байж болно. Энийг ч гэсэн та л бүтээдэг! Хүлээн зөвшөөрөхөд хэцүү ч та л бүтээсэн.

Заримдаа бид огт юм хийхгүй байсаар байгаад зарим нэг зүйлсийг бидэнд тохиолдох нөхцөлийг олгодог. Тухайлбал,

Хүүхдүүдээ бие дааж сургаагүйгээс болж хүүхдүүд нас биед хүрсэн ч амьдралаа авч явж чадахгүй. Та насны эцэст тэднийхээ төлөө сэтгэл шаналж дутууг нь өөрөө нөхөхөөс өөр аргагүй байдалд орно.

Нөхөр чинь анх удаа гар хүрэхэд нь та нухацтай ярилцаж зогсоох юм хийгээгүй учраас та түүнд дахиад л зодуулна.

Та өөрийгөө эрин үетэйгээ тохируулж хөгжүүлээгүй учраас, шинэ залуучууд гарч ирээд танаас өндөр цалин олгоход та нөгөө л хуучин хэвээрээ.



Машинаа багахан доголдолтой байхад нь үзэж засвар хийлгээгүйгээс болж, гэнэт гудамжинд суугаад эвдэрсэн машинаа хараан зүхнэ.

Эндээс харахад та өөрийгөө хохирогч биш гэдгээ хараарай. Та аливаа юм буруу эргэхэд шаардлагатай гэсэн үйлдэлийг хийгээгүй орхигдуулсанаас л ийм юм болсон. Та юу ч хийгээгүй, хэлээгүй, шаардаагүй, асуугаагүй, Үгүй гэж хэлээгүй, шинэ юм туршиж хийж үзээгүй...

## САНУУЛГА ДОХИО

Ямар нэгэн юмс үйл явдал танд санамсаргүй тохиолддоггүй. Сануулга дохио шиг ямар нэгэн урьдчилсан түгшүүр мэдрүүлэх дохионууд өгдөг. Заримдаа хэн нэгэн хүний сануулга үг, дотоод сэтгэлийн тавгүй мэдрэмж, зурвас бодол гэх мэт олон янзын хэлбэрээр хүсээгүй юм бий болох вий гэсэн ямар нэгэн хамгаалалт үйлдэл хийхийг сануулсан санамж дохио болж орж ирдэг.

**Та санамж дохиог байнга хүлээн авдаг. Заримдаа таны санамж дохионууд гаднаас ирдэг.**

Нөхөр чинь гэртээ ирэх нь улам л оройтсоор, хааяа үнэртүүлсэн ирдэг болж.

Ээж чинь чамд сануулж л байсан.

Найз чинь чамд хэлж л байсан.

**Заримдаа таны санамж дохионууд дотроосоо мэдрэгддэг.**

Нэг л зүрх түгшээд байсан.

Таагүй мэдрэмж орж ирээд байсан.

Нэг л айж зүрхшээгээд байсан.

Шөнө дунд хар дарж зүүдлээд л

**Заримдаа бид тэр болгоноо үгээр илэрхийлэхдээ иймэрхүү аргаар ярьдаг.**

Нэг л сэжиг төрөөд, сонин санагдаад, эргэлзээтэй юм шиг...

Надад нэг тийм юм бодогдоод...

Миний дотроос нэг л тийм юм хэлээд байх шиг...

Эдгээр санамж дохионууд орж ирэхдээ таныг  $YЯ + XY = YД$  томъёоны

Хариу Үйлдэл (ХҮ)-дээ ямар нэгэн өөрчлөлт хийх агшинг мэдрүүлдэг. Гэсэн ч маш олон хүмүүс энэ хариу үйлдэлүүдийн авчрах эрсдэлээс зайлсхийж өгөгдсөн санамж дохиог үл тоомсорлодог. Өөртөө эвгүй таагүй санагдсан тэр зүйлийг нүүр тулан дэлгэн ярихад хэцүү байдаг.

Үнсний саванд байгаа тамхины иш уруулын будагтай байна гээд нөхөртэйгөө тулж ярихад эвгүй. Төлөвлөөд байгаа ажил бүтэхгүй гэдгийг уулзалтын үеэр ам ангайж түрүүлж дуугарахад эвгүй. Итгэдэггүй хүн рүүгээ эгцэлж хараад үнэн үгээ хэлэхэд хэцүү.

*АМЬДРАЛ УЛАМ Л АМАРХАН БОЛДОГ.*

Тиймээс та эдгээр зүйлсийг харсан ч хараагүй юм шиг, мэдсэн ч мэдээгүй юм шиг өнгөрөх нь илүү хялбар, илүү өөрт амар, эвгүй байдалд орохгүй, амар амгаланг сахина, таныг эрсдэлээс хамгаалдаг тул...

## ЭНЭ БОЛ ХЯЛБАРХАН

Амжилтанд хүрсэн хүмүүс бодит байдлыг шууд нүүр тулж хэлж шийдэж чаддаг. Тэд өөртөө эвгүй байсан ч эрсдэлийг хүлээн авч, хариуцлагатайгаар хариу үйлдэл хийж хүссэн үр дүнгээ бий болгодог. Амжилтанд хүрсэн хүмүүс хямрал болтол нь хүлээж, хэн нэгэн хүн эсвэл бусад нөхцөл байдлыг гарсан асуудал дээрээ буруутгадаггүй.

Нэгэнт эхэлсэн л бол, санамж дохио мэдрэгдсэн даруйд нь лавшрахаас нь өмнө хариу үйлдэл хий. Амьдрал илүү хялбар болдог. Та сайжирсан үр дүнг дотроосоо ч гаднаасаа ч мэдэрч эхэлдэг. Урьд нь та дотроо бодохдоо “Би хохирогч шиг санагдаад байна. Би ашиглуулаад ч байгаа юм шиг.” гэж боддог байсан бол, үр дүн сайжраад ирсэний дараа бол “Надад одоо таалагдаж байна. Би хянаж өөрчлөлт хийж чаддаг юм байна. Би аливаа зүйлийг бий болгож чадна” гэж дотроо бодож эхэлдэг.

Гадна гардаг үр дүнгүүдээс заримдаа “Манай дэлгүүрт ордог хүн ч гэж байхаа байж, хүмүүс улам л мөнгөгүй болоод байна. Манай шинэ бараа сайн борлогдохгүй байгаа, энэ янзаараа бид алдагдалтай ажиллаж байна.” гэх мэтийн ярьдаг байсан ярианууд хариуцлагатай Хариу Үйлдэл хийсний дараагаар “Одоо манай дансанд арай ахиухан мөнгөтэй боллоо. Бид энэ салбарыг борлуулалтаараа тэргүүлэх боломжтой. Манай бараа тавиур дээрээсээ дорхноо алга болох юм” гэх мэтчилэнгээр солигдож болно.

## ЭНГИЙН БОЛОВЧ ХҮМҮҮС ХЭРЭГЖҮҮЛЖ ЧАДДАГГҮЙ

